ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"ДАРХАН-УС СУВАГ" ХК-ИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/1/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор Ч.Гантулга

Утас: 70378845 Цахим хаяг: gantulgach@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 2
Асуудлыг онцолсон хэсэг 3
Аудитын гол асуудал 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 10
4. АУДИТЫН ТАЙЛАН 14
4.1 Ерөнхий зүйл 14
4.2 Материаллаг байдал 14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 14
4.4.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 15
4.5.1 Завсрын аудитын талаар 15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ 16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНӨ	Орон нутгийн өмч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХСУХАТАҮЗЗ	Хот суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл
УОО	Урьдчилж орсон орлого

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 153

танай _____-ны №_____ -т

"ДАРХАН-УС СУВАГ" ОНӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ ДЭД ЗАХИРАЛ, ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Т.БУЯНДЭЛГЭР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дархан-Ус суваг" ОНӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2024 оны 10, 25, 37, 36, 13 дугаар тогтоолуудаар Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр "Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН 3244/3245 төсөл"-ийн хүрээнд бий болсон 39,559,240.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч, урт хугацаат өр төлбөрийн дансанд бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2024 оны 48 тоот тогтоолоор үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагуудын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг 25.2 хувиар, төсөвт байгууллагын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг 30 хувиар тус тус нэмэгдүүлсэн байна.

Бусад асуудал

Компанийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн жилийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг 79 хувьтай тайлагнасан ба хэрэгжих шатандаа 4, огт хэрэгжээгүй 2 арга хэмжээ байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1	**Эргэлтийн хөрөнгө**		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	96,529,924.00	15,752,228.17
1.1.2	Дансны авлага	749,363,689.35	699,671,312.32
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	9,447,870.50	6,789,004.29
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.6	Бараа материал	312,038,776.43	381,084,559.46
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	48,530,000.00	345,949,910.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	6,005,542,924.80	-
1.1.11	**Эргэлтийн хөрөнгийн дүн**	**7,221,453,185.08**	**1,449,247,014.24**
1.2.1	Үндсэн хөрөнгө	22,041,329,590.05	60,000,783,299.31
1.2.2	Биет бус хөрөнгө	9,263,956,339.38	11,314,997,347.67
1.2.3	Биологийн хөрөнгө	1,600,000.00	1,600,000.00
1.2.10	**Эргэлтийн бус хөрөнгийн дүн**	**31,306,885,929.43**	**71,317,380,646.98**
1.3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**	**38,528,339,114.51**	**72,766,627,661.22**
2.1.1.1	Дансны өглөг	231,472,642.98	378,356,652.26
2.1.1.2	Цалингийн өглөг	93,092,352.21	135,745,553.34
2.1.1.3	Татварын өр	152,663,279.45	286,969,536.80
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	9,969,880.05	11,336,371.98
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	21,716,662.00	26,801,871.57
2.1.1.13	**Богино хугацаат өр төлбөрийн дүн**	**508,914,816.75**	**839,209,985.95**
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	6,005,542,924.80	39,559,240,699.31
2.1.2.6	**Урт хугацаат өр төлбөрийн дүн**	**6,005,542,924.80**	**39,559,240,699.31**
2.2	**Өр төлбөрийн нийт дүн**	**6,514,457,741.55**	**40,398,450,685.26**
2.3.1	Төрийн өмч	3,384,431,409.00	3,384,431,409.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	11,609,461,293.02	11,609,461,293.02
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	36,879,239,437.22	39,815,363,579.82
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(19,859,250,766.28)	(22,441,079,305.88)
2.3.11	**Эздийн өмчийн дүн**	**32,013,881,372.96**	**32,368,176,975.96**
2.4	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ**	**38,528,339,114.51**	**72,766,627,661.22**

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1.1	**Үндсэн үйл ажиллагааны орлого**	-	-
1.1.1	Борлуулалтын орлого	8,403,577,411.95	10,933,051,262.88
1.1.20	**Борлуулалтын орлогын дүн**	**8,403,577,411.95**	**10,933,051,262.88**
1.2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	8,462,733,238.32	10,161,777,581.98
1.3	**Нийт ашиг алдагдал**	**(59,155,826.37)**	**771,273,680.90**
1.4.1	Цалин хөлс, шагнал	1,087,498,481.00	1,506,033,913.58
1.4.2	Нийгмийн даатгалын шимтгэл	176,736,316.00	198,781,289.92
1.4.4	Ашиглалтын зардал	14,352,639.00	15,214,012.98
1.4.6	Албан томилолтын зардал	15,879,789.00	22,785,170.03
1.4.8	Түүхий эд материалын зардал	70,537,756.00	80,753,842.92
1.4.9	Элэгдлийн зардал	176,362,604.00	167,981,679.76
1.4.10	Зар сурталчилгааны зардал	7,000,000.00	6,762,500.00
1.4.11	Шуудан холбооны зардал	6,627,960.00	11,068,277.90
1.4.12	Шатахууны зардал	33,976,612.00	31,090,406.96
1.4.16	Бусад зардал	367,596,541.00	
1.4.30	Үйл ажиллагааны зардлын дүн	1,956,568,741.00	3,977,654,565.18
1.5	Үндсэн үйл ажиллагааны ашиг алдагдал	(2,015,724,567.37)	(2,580,751,516.40)
2.1	Үндсэн бус үйлдвэрлэл үйлчилгээний ашиг алдагдал	860,550,087.64	
2.8	Бусад	(1,517,468,501.38)	(1,077,023.20)
2.20	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг алдагдлын дүн	(656,918,416.62)	**(2,581,828,539.60)**
3	**Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал**	**(2,672,642,983.99)**	**(2,581,828,539.60)**
6	**Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал**	**(2,672,642,983.99)**	**(2,581,828,539.60)**

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

	Үзүүлэлт	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг /алдагдал/	Нийт дүн
1	**2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл**	**3,384,431,409.00**	**-**	**10,852,595,172.91**	**35,824,366,162.76**	**(17,186,607,782.29)**	**32,875,054,962.38**
2	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	3,384,431,409.00	-	10,852,895,172.91	35,824,336,162.76	(17,186,607,782.29)	32,875,054,962.38
4	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	1,054,903,274.46	-	1,054,903,274.46
5	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	-	(2,672,642,983.99)	(2,672,642,983.99)
6	Ногдол ашиг	-	-	-	-	-	-
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	756,566,120.11	-	-	756,566,120.11
8	**2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл**	**3,384,431,409.00**	**-**	**11,609,461,293.02**	**36,879,239,437.22**	**(19,859,250,766.28)**	**32,013,881,372.96**
9	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-	-
10	Залруулсан үлдэгдэл	3,384,431,409.00	-	11,609,461,293.02	36,879,239,437.22	(19,859,250,766.28)	32,013,881,372.96
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-	-	-
12	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	2,936,124,142.60	-	2,936,124,142.60
13	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	-	(2,581,828,539.60)	(2,581,828,539.60)
14	Ногдол ашиг	-	-	-	-	-	-
15	Гаргасан хувьцаат капитал	-	-	-	-	-	-
16	**2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл**	**3,384,431,409.00**	**-**	**11,609,461,293.02**	**39,815,363,579.82**	**(22,441,079,305.88)**	**32,368,176,975.96**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**	-	-
1.1	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого**	**10,203,248,677.55**	**12,874,909,428.34**
1.1.1	Борлуулалтын болон худалдан авагчдаас орсон мөнгө	10,151,335,200.31	12,415,195,689.65
1.1.2	Туслах үйл ажиллагаанаас орсон мөнгө	51,913,477.24	459,713,738.69
1.2	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага**	**(10,009,271,183.71)**	**(12,955,687,124.17)**
1.2.1	Ажиллагчдад олгосон мөнгө	(2,577,238,432.72)	(3,969,164,475.31)
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	(930,100,000.00)	(1,254,060,314.00)
1.2.3	Түүхий эд, материал худалдан авахад төлсөн мөнгө	(5,500,564,979.00)	(5,479,798,994.70)
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	(1,525,636.74)	-
1.2.10	Бусад үйл ажиллагааны мөнгөн зардал	(999,842,135.25)	(2,252,663,340.16)
1.20	**Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**193,977,493.84**	**(80,777,695.83)**
3.2	Банкнаас авсан зээл	200,000,000.00	630,000,000.00
3.3	Хүүгийн орлого	27,983.45	-
3.7	Урт хугацаат өрийн тайлангийн хугацааны төлөлт	(318,631,538.01)	(630,000,000.00)
3.20	**Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**(118,603,554.56)**	**-**
4	**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**	**75,373,939.28**	**(80,777,695.83)**
4.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	21,155,984.72	96,529,924.00
4.2	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	96,529,924.00	15,752,228.17

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Зардлын нэр	2024 он			
		төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
	ОРЛОГО				
1	Усны борлуулалтын орлого	11,356,967,232.00	10,933,051,262.89	(423,915,969.11)	96.3
2	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	375,768,352.73	625,629,366.98	249,861,014.25	166.5
	ОРЛОГЫН ДҮН	11,732,735,584.73	11,558,680,629.87	**(174,054,954.86)**	**98.5**
1	Цалин	4,763,342,499.98	4,631,147,716.96	(132,194,783.02)	97.2
2	НДШимтгэл	702,538,244.53	637,035,543.13	(65,502,701.40)	90.7
3	Албан томилолт	52,984,000.00	43,007,632.61	(9,976,367.39)	81.2
4	Түүхий эд материал	650,768,522.82	1,294,809,962.40	644,041,439.58	199.0
5	Багаж хэрэгсэл	84,082,483.91	84,346,064.15	263,580.24	100.3
6	Цэвэрлэгээний материал	9,326,654.64	7,953,776.94	(1,372,877.70)	85.3
7	Шуудан холбоо	34,657,874.25	34,559,841.56	(98,032.69)	99.7
8	ШТМ	451,086,145.20	377,484,001.77	(73,602,143.43)	83.7
9	Үндсэн хөрөнгийн элэгдэл	3,575,508,441.77	3,215,630,416.70	(359,878,025.07)	89.9
10	Бичиг хэрэг	37,437,278.10	34,334,391.47	(3,102,886.63)	91.7
11	Ус	14,230,450.56	17,050,806.35	2,820,355.79	119.8
12	Дулаан	63,621,474.00	56,830,866.25	(6,790,607.75)	89.3
13	Цахилгаан	930,420,670.80	849,157,624.15	(81,263,046.65)	91.3
14	Хоол, унаа	366,956,000.00	332,384,000.00	(34,572,000.00)	90.6
15	Хөдөлмөр хамгаалал	239,224,369.45	219,563,550.57	(19,660,818.88)	91.8
16	Сургалт дотоод	118,622,000.00	96,723,818.18	(21,898,181.82)	81.5
17	Нөхөн сэргээлт	159,330,000.00	183,624,385.57	24,294,385.57	115.2
18	Аваарын хоол	27,072,000.00	38,154,136.37	11,082,136.37	140.9
19	Нөөц сан	-	3,233,148.11	3,233,148.11	-
20	Бусдаар гүйцэтгүүлэх	301,779,926.84	309,954,968.99	8,175,042.15	102.7
21	Зар сурталчилгаа	19,600,000.00	17,042,477.25	(2,557,522.75)	87.0
22	Хамгаалах салаа	63,210,968.00	65,457,755.33	2,246,787.33	103.6
23	Зээлийн хүүгийн зардал	-	25,382,794.50	25,382,794.50	-
24	Зохицуулах үйлчилгээний төлбөр	65,439,338.00	65,439,338.10	0.10	100.0
25	Татвар	35,182,793.99	33,861,417.19	(1,321,376.80)	96.2
26	Даатгалын зардал	22,086,712.45	20,024,180.83	(2,062,531.62)	90.7
27	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	1,000,806,915.30	1,446,314,554.04	445,507,638.74	144.5
	БАЙГУУЛЛАГЫН НИЙТ ЗАРДАЛ	**13,789,315,764.59**	**14,140,509,169.47**	**351,193,404.88**	**102.5**
	АШИГ, АЛДАГДАЛ	**(2,056,580,179.86)**	**(2,581,828,539.60)**	**(525,248,359.74)**	**125.5**

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компаний үйл ажиллагаа

"Дархан-Ус суваг" ОНӨХК-ийн зорилго нь Хэрэглэгчдийг унд ахуйн стандартад тохирсон цэвэр усаар хангаж, экологийн тэнцвэрт нийцсэн бохир усыг байгальд нийлүүлэхэд оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг ард иргэд, айл өрхүүд, аж ахуйн нэгж байгууллагуудыг цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах ажлыг тасралтгүй найдвартай хангах гэж тодорхойлжээ.

Тус байгууллага нь 100 хувь орон нутгийн өмчит бөгөөд үүнээс 60 хувийг нутгийн өөрөө удирдах байгууллага болох аймгийн ИТХ, 40 хувийг аймгийн ЗДТГ эзэмшиж байна.

"Дархан-Ус суваг" ХК нь тайлант хугацаанд дараах зорилтуудыг тавьж ажилласан байна.

- Цэвэр бохир усны хуримтлагдсан авлагыг өмнөх оноос 10 хувиар бууруулах,
- Хэрэглэгчийн хүйтэн усны хуучин тоолуурыг ухаалаг тоолуураар солих,
- Гэр хорооллын ундны усны хүртээмж, эрүүл, аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх, бодлогын баримт бичиг боловсруулж, хэрэгжүүлэх,
- Хуучирсан шугам хоолойг шинэчлэн солих зардлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгуулах,
- Компанийн зөв дүр төрхийг илэрхийлсэн нэгдсэн "Брэндбүүк"-ийг нэвтрүүлэх,
- Ажилчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх чиглэлээр багц сургалтуудад хамруулах,
- Компанийн үйл ажиллагааны төрөл бүрээр "Эрсдэлийн хяналт, үнэлгээний хуудас" боловсруулах,
- Гүний худгийн барилгуудад их засвар хийж, шинэчлэх,
- Бохир усны худаг, камерт техникийн үзлэг хийж дэвшилтэт төхөөрөмж нэвтрүүлэх,
- Өр төлбөрийг 35 хувиар бууруулах

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

"Дархан-Ус суваг" ОНӨХК нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2003 оны 09 дүгээр тогтоолыг үндэслэн байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд *"Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;..."* гэж заасантай нийцэж байна.

Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 15 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлсан нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12-д *"Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх"*, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-д *"Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;"*, 75 дугаар зүйлийн 75.4-д *"Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна"*, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 2.10 дахь заалтуудын дагуу томилсон нь холбогдох хууль эрх зүйн актуудтай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын "2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.10-*т "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг*

сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно" гэж заасан байна.

Тайлант хугацаанд Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлт орсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

"Дархан-Ус суваг" ОНӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьяар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

"Дархан-Ус суваг" ОНӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,455,579.4 мянган төгрөгөөр буюу 40 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	96,529.9	15,752.2	(80,777.7)
Авлага	758,811.6	706,460.3	(52,351.3)
Бараа материал	312,038.8	381,084.6	69,045.8
Урьдчилж төлсөн зардал тооцоо	48,530.0	345,949.9	297,419.9
Бусад эргэлтийн хөрөнгө	6,005,542.9	-	(6,005,542.9)
Үндсэн хөрөнгө	31,306,885.9	71,317,380.6	40,010,494.7
Нийт хөрөнгө	**38,528,339.1**	**72,766,627.7**	**34,238,288.6**
Нийт өр төлбөр	**6,514,457.8**	**40,398,450.7**	**33,883,992.9**
Богино хугацаат өглөг	508,914.8	839,210.0	330,295.2
Урт хугацаат өглөг	6,005,542.9	39,559,240.7	33,553,697.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	32,013,881.3	32,368,177.0	354,295.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	**38,528,339.1**	**72,766,627.7**	**34,238,288.6**

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 15,752.2 мянган төгрөг нь цэвэр ус болон бохир ус татан зайлуулсны орлогын үлдэгдэл байна.

Авлага дансны үлдэгдэл 706,460.3 мянган төгрөгийн 569,835.8 мянган төгрөг нь айл өрх, аж ахуйн нэгжийн усны төлбөрийн, 3,971.5 мянган төгрөг нь НӨАТ-ын, 2,817.5 мянган

төгрөг нь НДШ-ийн авлагын, 1,699.8 мянган төгрөг нь ажилчин албан хаагчдаас авах авлага байна. Ажилтан албан хаагчаас авах авлагын 96 хувь буюу 128,135.7 мянган төгрөг шүүхийн шатанд хянагдаж байна.

Урьдчилж төлсөн зардлын үлдэгдэл 345,949.9 мянган төгрөгийн 48,530.0 мянган төгрөг нь цэвэр усны үйлдвэр барих урьдчилгаа төлбөртэй холбоотой үүссэн ба тайлант онд уг үйлдвэр стандартын шаардлага хангаагүй тул орон нутгийн комисс хүлээж аваагүй, 261,823.7 мянган төгрөг нь гадна фасад, нэг давхрын засварын урьдчилгаа төлбөр, 7,500.0 мянган төгрөг нь эрчим хүчний давтан аудитын төлбөр, 28,096.2 мянган төгрөг нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх төлбөр байна.

Бараа материал өмнөх оноос 69,045.8 мянган төгрөгөөр өссөн нь 2,651,041.5 мянган төгрөгийн бараа материалыг орлогод авч, 3,271.8 мянган төгрөгийн бараа материалыг акталж, 2,578,723.9 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулжээ. Аймгаас инженерийн шугам сүлжээний засвар шинэчлэлийн ажлын захиалга ирснээс хангамжийн материалын 471,184.3 мянга, ус хангамжийн материал 763,410.8 мянга, сэлбэг хэрэгсэл 158,009.7 мянга, шатах тослох материал 752,981.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 71,317,380.6 мянган төгрөг болж, 40,010,494.7 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2023 оны 37, 59 дугаар тогтоолуудаар "Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН 3244/3245 төсөл"-ийн хүрээнд хүлээн авсан 39,559,240.7 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хүлээн авсан 1,054,903.3 мянган төгрөгийн, хөрөнгийн дахин үнэлгээгээр 756,566.1 мянган төгрөгийн, өөрийн хөрөнгөөр худалдан авсан 657,183.2 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус орлогод авч тайланд тусгасан нь нөлөөлсөн байна. Харин аймгийн Засаг даргын 2023 оны 01-А/333 тоот захирамжаар цаашид ашиглах боломжгүй 1,923,587.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан, хөрөнгийн хорогдолд 304,022.4 мянган төгрөг тооцсон, хөрөнгийн дахин үнэлгээгээр 3,782,829.8 мянган төгрөг бууруулсан байна.

Тайлант онд 2,127,864.3 мянган төгрөгөөр хуримтлагдсан элэгдэл буурсан нь тайланд онд хөрөнгө дахин үнэлсэнтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 839,210.0 мянган төгрөг болж, 330,295.2 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд татварын өглөг 8,031.6 мянган төгрөгөөр, ажилчид болон аж ахуйн нэгжийн өглөг 262,059.4 мянган төгрөгөөр, урьдчилж орсон орлого 1,576.9 мянган төгрөгөөр, бусад богино хугацаат өглөг 4,548.4 мянган төгрөгөөр бууруулсан нь голлон шалтгаалжээ.

Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН3244/3245 төслийн эргэн төлөлтийн урт хугацаат зээл 39,559,240.7мянган төгрөг бүртгэгдсэн байна.

Эздийн өмчийн дансны үлдэгдэл 32,368,177.0 мянган төгрөг болж 354,295.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө хүлээн авсан, хөрөнгийн дахин үнэлгээ хийж, эздийн өмчийн бусад хэсэг дансыг нийт 2,936,124.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн, тайлант хугацааны алдагдал 2,581,828.5 мянган төгрөгөөр хуримтлагдсан ашиг буурсан зэргээс шалтгаалжээ.

Байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого 2,529,473.8 мянган төгрөгөөр буюу 30 хувиар өссөн нь ХСУХАТАҮЗЗ-ийн 2024 оны 48 дугаар тогтоолоор үйлдвэр аж ахуйн нэгжийн цэвэр, бохир усны үнийн тарифыг 25.2 хувиар, төсөвт байгууллагын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг 30 хувиар нэмэгдүүлж, айл өрх, аж ахуйн нэгжийн зүй бус хэрэглээг илрүүлж алданги, нөхөн бичилт хийснээс шалтгаалсан байна. Харин бусад орлого өмнөх оноос 234,892.7 мянган төгрөгөөр буюу 27 хувиар буурсан нь инженерийн шугам сүлжээний засвар, шинэчлэлтийн захиалгын ажил багассантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 1,699,044.4 мянган төгрөгөөр буюу 20 хувиар өссөн нь цалингийн зардал өмнөх оноос 1,472,158.8 мянган төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу "Дархан-Ус суваг" ОНӨХК үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

"Дархан-Ус суваг" ОНӨХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 12 дугаар тогтоолоор "Дархан-Ус суваг" ХК-ийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 11,294,294.3 мянган төгрөгөөр, нийт зардлыг 13,567,115.7 мянган төгрөгөөр, 2,272,821.4 мянган төгрөгийн алдагдалтай байхаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 2,845,651.5 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Тайлант онд бизнес төлөвлөгөөг 2 удаа тодотгож, 2024 оны 03 дугаар тогтоолоор нийт орлогыг 11,732,735.6 мянган төгрөгөөр, нийт зардлыг 13,789,325.8 мянган төгрөгөөр, алдагдлыг 2,581,828.5 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

Гүйцэтгэлээр 11,558,680.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 14,140,509.2 мянган төгрөгийн зардал гарган, 2,581,828.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 11,558,680.7 мянган төгрөг болж төлөвлөснөөс 174,054.9 мянган төгрөг буюу 1.5 хувиар буурсан нь инженерийн шугам сүлжээний засвар, шинэчлэлтийн захиалгын ажил буурсантай холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 14,140,509.2 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 351,183.4 мянган төгрөг буюу 2.5 хувиар хэтэрсэн байна. Үүнд түүхий эд материалын зардал 644,041.4 мянган төгрөгөөр, зээлийн хүүгийн зардал 25,382.8 мянган төгрөгөөр, удирдлага, борлуулалтын зардал 38,815.1 мянган төгрөгөөр, шугам хоолойн засварын зардал 87,635.9 мянган төгрөгөөр, мэргэжлийн уралдаан тэмцээний зардал 22,368.5 мянган төгрөгөөр тус тус хэтэрсэн нь голлон нөлөөлжээ.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу шууд худалдан авалтаар 98 нэр төрлийн 1,493,611.5 мянган төгрөгийн, харьцуулалтын аргаар 567,018.8 мянган төгрөгийн, нээлттэй тендер шалгаруулалтаар 1,325,629.7 мянган төгрөгийн, нийт 3,386,260.0 мянган төгрөгийн худалдан авалт хийж, хөрөнгө зарцуулсан байна.

Тайлант онд цэвэр алдагдал 2,581,828.5 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 525,238.4 мянган төгрөгөөр өссөн нь төлөвлөгдөөгүй хүү, торгуулийн зардал гарсан, үндсэн хөрөнгө нэмэгдэж, элэгдлийн зардал өссөн зэргээс шалтгаалжээ

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу "Дархан-Ус суваг" ОНӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгснийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Гантулга гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

"Дархан ус суваг" ОНӨХК нь 2024 оны санхүүгийн тайланг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн № 02/63 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны тодотгосон бизнес төлөвлөгөөний орлогын дүнг сонгож, эрсдэлийн түвшнийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2024 оны бизнес төлөвлөгөөний зардлын дүн 13,789,325.8 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 137,893.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 96,525.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор бизнес төлөвлөгөөний батлагдсан төсвөөс цахилгааны зардлыг 81,263.0 мянга, шатахууны зардлыг 73,612.1 мянга, хоол, унааны зардлыг 34,572.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд компанийн батлагдсан зардлаас спортын тэмцээн уралдаанд оролцогчдод 4,031.5 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т *"Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"* гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь хэсэгт заасантай нийцэхгүй байгаа тул Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, компанийн хөрөнгөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан ба нийт 19,804.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс зөвлөмж өгч, хэрэгжилтийг 2024 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 01/274 тоот албан бичгээр ирүүлсэн. Аудитаар зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	19,804.0	3	19,804.0	100
Нийт дүн	**3**	**19,804.0**	**3**	**19,804.0**	**100**

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд болон эрсдэлтэй ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэлд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнгээр алдаа, зөрчил илрээгүй болно.

Тайлангийн 4.4. 2 дахь хэсэгт дурдсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[1]-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Спортын тэмцээн уралдаанд оролцогчдод дэмжлэг үзүүлсэн	1	4,031.5	-	-	-	-	1	4,031.5	-	-	-	-
Дүн	**1**	**4,031.5**	**-**	**-**	**-**	**-**	**1**	**4,031.5**	**-**	**-**	**-**	**-**

[1] .Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.